



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 1/94


Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220578

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02
дугаар сарын 18 - ны өдрийн 1/94
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

| № | Эрүүл мэндийн байгууллагын нэрс | Батламжийн Дугаар | Магадлан итгэмжлэг дсэн хугацаа | Үнэлгээний нийт дүн | Магадлан итгэмжлэл эхлэх огноо | Магадлан итгэмжлэл дуусах огноо |
|-----|--|-------------------|---------------------------------|---------------------|--------------------------------|---------------------------------|
| 1. | Чингэлтэй дүүрэг, "Цэнгэл жаргал хайрхан" өрхийн эрүүл мэндийн төв | 1/2022 | 3 жил | 90,4% | 2022.01.22 | 2025.01.22 |
| 2. | Хан-Уул дүүрэг, "Мөнхбадрах өрх" өрхийн эрүүл мэндийн төв | 2/2022 | 2 жил | 88,0% | 2022.01.22 | 2024.01.22 |
| 3. | Баянзүрх дүүрэг, "Энх Энэрэл" өрхийн эрүүл мэндийн төв | 3/2022 | 3 жил | 91,2% | 2022.01.12 | 2025.01.12 |
| 4. | Баянгол дүүрэг, "Ашид амгалан" өрхийн эрүүл мэндийн төв | 4/2022 | 4 жил | 92,0% | 2022.02.11 | 2026.02.11 |
| 5. | Баянзүрх дүүрэг, "Мараната" өрхийн эрүүл мэндийн төв | 5/2022 | 2 жил | 87,5% | 2022.02.11 | 2024.02.11 |
| 6. | Улаанбаатар, Хотонтрейд ХХК-ийн "Энхжил" эмнэлэг | 6/2022 | 2 жил | 87,7% | 2022.01.30 | 2024.01.30 |
| 7. | Улаанбаатар, "Цу-Эрдэнэ" ХХК-ийн эмнэлэг | 7/2022 | 2 жил | 85,8% | 2022.02.11 | 2024.02.11 |
| 8. | Улаанбаатар, "Нэмүүн төгс" ХХК-ийн сувилал | 8/2022 | 2 жил | 88,0% | 2022.02.11 | 2024.02.11 |
| 9. | Улаанбаатар, "Асралт мед" ХХК-ийн эмнэлэг | 9/2022 | 3 жил | 91,3% | 2022.02.11 | 2025.02.11 |
| 10. | Дорнод аймгийн "Гурванзагал" сумын эрүүл мэндийн төв | 10/2022 | 2 жил | 87,0% | 2022.02.11 | 2024.02.11 |
| 11. | Дорнод аймгийн "Цагаан-Овоо" сумын эрүүл мэндийн төв | 11/2022 | 3 жил | 91,6% | 2022.02.11 | 2025.02.11 |
| 12. | Сэлэнгэ аймгийн "Түшиг" сумын эрүүл мэндийн төв | 12/2022 | 2 жил | 86,2% | 2022.01.20 | 2024.01.20 |
| 13. | Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" сумын эрүүл мэндийн төв | 13/2022 | 1 жил | 82,5% | 2022.02.14 | 2023.02.14 |
| 14. | Сэлэнгэ аймгийн "Бугант" тосгоны эрүүл мэндийн төв | 14/2022 | 2 жил | 86,6% | 2022.01.20 | 2024.01.20 |
| 15. | Өвөрхангай аймгийн "Нарны дөш" өрхийн эрүүл мэндийн төв | 15/2022 | 4 жил | 93,8% | 2022.01.03 | 2026.01.03 |